



Аудитын код: САГ-2018/46/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn


Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512 Цахим хаяг: nyamdavaa@audit.gov.mn

Гүйцэтгэсэн:
Ниямазон аудит ХХК
Захирал З.Цээнээ
Утас: 70145906 Цахим хаяг: niyamazon_audit@yahoo.com

Ахлах аудитор Ж.Батнасан
Утас: 70145906 Цахим хаяг: nasaa27@yahoo.com



Улаанбаатар хот

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	1
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
2.5	Дотоод хяналт.....	6
2.6	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга.....	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	9
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	өөрийн хөрөнгийн талаар.....	12
3.2	Үндсэн хөрөнгийн талаар	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, тодруулга	15
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлынтайлан.....	15
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.5	Аудит хийгдсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт	17

1 Аудитын гэрчилгээ

"ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна

Санал дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын



олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн аудитын тайланг "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн захирал Б.Отгонсүх танд толилуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд зохих байгууллагуудаар шийдвэрлүүлэн хөрөнгө, хувьцааны бүртгэлийг хийх, улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах, Эрчим хүчний яаманд шийдвэргүй шилжүүлсэн автомашины асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдүүлэх зөвлөмжийг тусгалаа.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 15-наас 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, САГ-2018/46/СТА-ТӨҮГ



компанид хүргүүлэхээр төлөвлөн, Ниямазон аудит ХХК-ийн аудиторууд хариуцаж хэрэгжүүлэв.

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгаа 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 01/31 дүгээр албан бичгээр Ниямазон аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", "Санхүүгийн тайлангийн маягт", 2002 оны 191 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал" зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны 117 дугаар тогтоолоор "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-г байгуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 132 дугаар тогтоолоор компанийн дүрэм, бүтэц, орон тоог баталж, 133 дугаар тогтоолоор компанийн захирлыг томилжээ.

Эрчим хүчний сайдын 2017 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 63 дугаар тушаалаар "Эгийн голын усан цахилгаан станц төсөл"-ийн нэгжийг татан буулгаж, 2017 оны 5 дугаар сарын 25-наар дуусгалтын тайланг бэлтгэж, хөрөнгийг компанид балансаас балансад шилжүүлсэн байна.

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн үндсэн зорилго нь Эгийн голын усан цахилгаан станцын төслийг хугацаанд нь чанартай, бүрэн хэрэгжүүлж, түлхүүр гардуулах нөхцөлөөр станцыг барьж ашиглалтад оруулж, Монгол Улсын эрчим хүчний системийн бие даасан байдлыг ханган, үүсгүүр хүчин чадлын бүтцийг өөрчлөн сайжруулж, тогтвортой ажиллагааг нь дээшлүүлэн аваарын болон нөөцийн хүчин чадалтай, оргил ачааллын горим тохируулгын найдвартай ажиллагааг бүрэн хангахад оршино.


Компани нь Эгийн голын усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна.

- техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, бусад техникийн баримт бичгийг боловсруулах;
- байгаль орчин, нийгмийн нөлөөлийн болон бусад судалгааны ажлыг хийж гүйцэтгэх;
- санхүүжилтийн нөхцөлийг тодорхойлж шийдвэрлүүлэх, санхүүжилтийн эргэн төлөлтийг хариуцах;
- барилгын ажлын захиалагчийн үүргийг гүйцэтгэж, хяналт тавьж, ашиглалтад оруулах;
- үйл ажиллагааг эрхлэн явуулж, цахилгаан үйлдвэрлэн төвийн эрчим хүчний нэгдсэн системд нийлүүлэх.

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох САГ-2018/46/СТА-ТӨҮГ



бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, тодруулгын дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 12 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

- 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн ТС-ЭГ-ЗҮ 2017/131 дүгээр "Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ"-г зээлдүүлэгч Монгол Улсын Хөгжлийн банк, захиалагч Эрчим хүчний яам, хувьцаа эзэмшигч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, зээлдэгч "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК байгуулжээ.

Гэрээнд "Эгийн голын усан цахилгаан станц төсөл"-ийн нэгжид зориулж авсан Эрчим хүчний яамны 7,498.2 мянган ам.доллар болон 1,633.3 сая төгрөгийн зээлийг хуримтлагдсан хүүгийн төлбөрийн нийлбэр дүнгээр "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-д шилжүүлж, үйл ажиллагааны зардалд 2,500.0 мянган ам.долларыг жилийн 9.75 хувийн хүүтэйгээр нэмж олгохоор тусгажээ.

Компанид шилжүүлсэн зээлийн тооцоо

Үндсэн зээл		Хуримтлагдсан хүү		Нийт дүн	
Ам.доллар	Төгрөг	Ам.доллар	Төгрөг	Ам.доллар	Төгрөг
7,498,234.97		1,210,235.18		8,708,470.15	21,480,660.80
	1,633,293,254.70		97,220,448.23	701,567.19	1,730,513,702.93
7,498,234.97	1,633,293,254.70	1,210,235.18	97,220,448.23	9,410,037.34	23,211,174,513.73
				ханш	2,466.64

Дээрх гэрээний дагуу 2017 оны 09 дүгээр сарын 26-нд 9,410.0 мянган ам.долларын өрийг компанид шилжүүлж, үйл ажиллагааны зардалд 412.0 мянган ам.долларыг олгосон байна. Тайлант онд 617.7 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардал гарч, урт хугацаат зээлийн өглөг 23,839.7 сая төгрөг болжээ.

- "Урьдчилж төлсөн зардал ТЭЗҮ" дансанд техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахтай холбоотой гэх зардлуудыг 2014 оноос хуримтлуулан бүртгэж, 11,229.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Зардлын задаргаа	Нийт дүн /мянган төгрөгөөр/
Монгол Улсын Хөгжлийн банк /зээлийн хүү/	2,246,800.70
Трактебел инженеринг	3,148,174.30



Байгаль хамгаалах тул сан	1,425,376.70
Зөвлөхийн цалин	151,142.80
Бусад	4,257,986.00
Нийт	11,229,480.50

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 279 дүгээр тогтоолоор "Эгийн голын усан цахилгаан станц төсөл"-ийн нэгжийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 327.8 сая төгрөгийн хөрөнгийг "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-д балансаас балансад шилжүүлж, 166.1 сая төгрөгийн "Тоёото ландкрузер 200" маркийн 75-52 унд улсын дугаартай автомашиныг "Аялал жуулчлалын хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад шилжүүлсэн байна.

Тус компанийн тайланд 5 автомашин бүртгэлтэй байгаа боловч Ландкрузер 78 маркийн 91-34 унд улсын дугаартай автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан бичигт дурдснаар Орхон аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төвд шилжүүлсэн гэх боловч хөрөнгө шилжүүлэх тогтоол гараагүй байна.

	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын дугаар	Анхны үнэ	Ашиглаж буй байгууллага
1	Toyota Landruiser GX 200	75-52 УНД	116,100,000	Компани
2	Toyota Landruiser 76	81-31 УНД	86,040,000	Орхон аймгийн бүсийн оношлогоо, эмчилгээний төв
3	Toyota Landruiser 78	91-34 УНД	80,000,000	Компани
4	Соната	43-40 УНД	49,300,000	Компани
5	Nissan patrol	61-89 УНА	135,000,000	Эрчим хүчний яам
	Нийт дүн		466,440,000	


"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Компани санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн "Эрхэт" онлайн програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.



2.6 ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 210 дугаар тогтоолоор "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төсвийг баталж, 2017 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 384 дүгээр тогтоолоор тодотгон баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	2017 оны тодотгол	Гүйцэтгэл	Зөрүү
Нийт зардал	1,452,601.5	863,667.6	588,933.9
Урсгал зардал	1,007,637.5	851,719.6	155,917.9
Үүнээс: удирдлагын зардал	124,320.0	111,037.6	13,282.4
Хөрөнгө оруулалтын зардал	8,985.0	11,947.9	(2,997.9)
Биологийн олон янз байдлын судалгаа	300,000.0	0.0	300,000.0
Нийт авлага	850.0	957.4	107.4
Нийт өглөг	26,116,425.4	24,613,431.7	1,502,993.7
Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	3,696,027.2	773,743.7	2,922,283.5
Урт хугацаат өр төлбөр	22,420,398.2	23,839,688.0	(1,419,289.8)
Нийт ажиллагсдын тоо	28	28	0.0
Нийт цалингийн сан	521,977.5	451,934.4	70,043.1
Нэг ажилчны дундаж цалин	18,642.1	16,140.5	2,501.6

Компанийн урсгал зардлыг 1,007.6 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 8.9 сая төгрөгөөр, биологийн олон янз байдлын судалгааны зардлыг 300.0 сая төгрөгөөр, нийт 1,452.6 сая төгрөгийн төсөв баталжээ.

Гүйцэтгэлээр нийт зардлыг 588.9 сая төгрөгөөр хэмнэсэн нь биологийн олон янз байдлын судалгааны санхүүжилт хийгдээгүйгээс шалтгаалжээ.

2.7 Шилэн дансны мэдээлэл

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.eghpp.mn сайтад шилэн дансны цэсийг холбож, холбогдох мэдээллийг оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.


Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Балансаас балансад хөрөнгө шилжүүлсэн талаар

- Төслийн нэгжийн дуусгалтын тайланд нийт хөрөнгө 11,710.2 сая төгрөг, өр төлбөр 22,569.8 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн (10,859.6) сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч компани балансын эхний үлдэгдлээр бүртгэсэн боловч Төрийн өмчийн



бодлого, зохицуулалтын газар 279 дүгээр тогтоолоороо зөвхөн 327.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 21.2 сая төгрөгийн бараа материал, нийт 349.0 сая төгрөгийн хөрөнгийг л компанид балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал, өр төлбөрийг шилжүүлэх шийдвэрийг өнөөг хүртэл гаргаагүй байна.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 132 дугаар тогтоолоор баталсан компанийн дүрмийн 3.1-д "компанийн өөрийн хөрөнгө хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 119,043,986 ширхэг энгийн хувьцаатай байна" гэж заасан нь хэрэгжиж бүртгэгдээгүй байна.
- Мөн Улсын бүртгэл, оюуны өмчийн газар компанийн дүрмийг баталгаажуулж, гэрчилгээ шинээр олгохдоо өмчийг 20.0 мянган төгрөгөөр тусгасан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол, компанийн дүрэмтэй нийцэхгүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт болон холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн хөрөнгө, хувьцааны бүртгэлийг хийх, гэрчилгээнд өөрчлөлт оруулах зөвлөмж өгөх

2.9.2 Үндсэн хөрөнгийн талаар

Тус компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй "Ниссан патрол" маркийн 61-89 уна улсын дугаартай автомашиныг төслийн нэгжийн үед Эрчим хүчний яамны албан хэрэгцээнд 2016 оны 8 дугаар сард акт үйлдэн хүлээлцэхдээ зохих байгууллагаар шийдвэр гаргуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд "төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр шилжүүлж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх автомашины асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөх

2.9.3 Урьдчилж төлсөн зардлын талаар


"Эгийн голын усан цахилгаан станц төсөл"-ийн нэгж нь "Вивид технологи" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн системийг 9.9 сая төгрөг, е-оффис програмыг 8.8 сая мянган төгрөгөөр суурилуулж, ашиглах гэрээ байгуулж, 2015 оны 12-р сарын 25-нд 14.9 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Гэрээний дагуу хийгдсэн ажлын гүйцэтгэл тодорхойгүй, нотлох баримтгүй, дансанд үлдэгдэлтэй байгаа боловч төслийн нэгж 2016 оны жилийн эцэст үлдэгдэлгүй хэмээн тооцоо нийлсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор баталсан дүрмэнд өөрийн хөрөнгийг алдаатай тусгасан, компанийн захиралтай байгуулсан контракт гэрээний зарим заалт, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төсөвтэй зөрчилдсөн байгаа тул тус газраас төрийн өмчит компаниудын САГ-2018/46/СТА-ТӨҮГ



талаар гаргасан тогтоол, шийдвэрүүдийн уялдаа холбоог анхаарч үзэх шаардлагатай байна.

"Урьдчилж төлсөн зардал ТЭЗҮ" дансанд техник эдийн засгийн үндэслэл боловруулахтай холбоотой гэх зардлуудыг 2014 оноос хуримтлуулан бүртгэж, 2017 оны санхүүгийн тайланд 11,229.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд "Эгийн голын усан цахилгаан станц төсөл"-ийн 2013-2016 оны техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох судалгаа материал, санхүүгийн баримтуудыг Эрүүгийн цагдаагийн газар хураан авч шалгаж байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан зардлыг нарийвчлан шалгаж, баталгаажуулан хөрөнгөөр бүртгэх талаар судалж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитаар нийт 14.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ


"Эгийн голын усан цахилгаан станц" төслийн нэгжийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн байна.

- Монгол Улсын Засгийн газрын гаргасан үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүдийн нэгжийн үйл ажиллагаа болон бусад эрх, үүргийг зохицуулсан эрхийн актыг шинэчлэн боловсруулах зөвлөмжийн дагуу Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан журмыг шинэчлэх талаар холбогдох байгууллагад бичиг хүргүүлсэн байна. Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 117 дугаар тогтоолоор компани болсон учраас Компанийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллага журмын дагуу ажлын хэсэг томилж, төслийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж тайлан гаргах зөвлөмжийн хүрээнд Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу "Эгийн голын усан цахилгаан станц төсөл"-ийн санхүүжилт, зарцуулалт, сонгон шалгаруулалт, гэрээ хэрэгжилтийн хугацаа, гүйцэтгэлийн чанар, төслийн үр дүн, түүний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, тайлан гаргажээ.
- Түрээсийн зардлыг бууруулах зөвлөмжийн дагуу түрээслүүлэгч "Камдер" ХХК-тай 2017 оны 3 дугаар сард түрээсийн 1 мкв-ын үнийг 35000 төгрөг байсныг 28570 төгрөг болгон бууруулсан шинэ гэрээ байгуулжээ.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,967.2 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 19.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгыг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул "зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Бид аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ЫН АЖИГЛАЛТ

Төслийн нэгжийн дуусгалтын тайланд нийт хөрөнгө 11,710.2 сая төгрөг, өр төлбөр 22,569.8 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн (10,859.6) сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч компани балансын эхний үлдэгдлээр бүртгэсэн боловч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 279 дүгээр тогтоолоороо зөвхөн 327.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 21.2 сая төгрөгийн бараа материал, нийт 349.0 сая төгрөгийн хөрөнгийг л компанид балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал, өр төлбөрийг шилжүүлэх шийдвэрийг өнөөг хүртэл гаргаагүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 132 дугаар тогтоолоор баталсан компанийн дүрмийн 3.1-д "компанийн өөрийн хөрөнгө хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 119,043,986 ширхэг энгийн хувьцаатай байна" гэж заасан нь хэрэгжиж бүртгэгдээгүй байна.

Мөн Улсын бүртгэл, оюуны өмчийн газар компанийн дүрмийг баталгаажуулж, гэрчилгээ шинээр олгохдоо өмчийг 20.0 мянган төгрөгөөр тусгасан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол, компанийн дүрэмтэй нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

ҮАГ-ЫН ЗӨВЛӨМЖ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт болон холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн хөрөнгө, хувьцааны бүртгэлийг хийх, гэрчилгээнд өөрчлөлт оруулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй "Ниссан патрол" маркийн 61-89 уна улсын дугаартай автомашиныг төслийн нэгжийн үед Эрчим хүчний яамны албан хэрэгцээнд 2016 оны 8 дугаар сард акт үйлдэн хүлээлцэхдээ зохих байгууллагаар шийдвэр гаргуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд "төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр шилжүүлж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан автомашины асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, тодруулга

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлынтайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/мянган төгрөгөөр/	
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
АВЛАГА		
Бусад авлага		
Байгууллагаас авах авлага		
БАРАА МАТЕРИАЛ		
Түүхий эд материал		
Тусгай зориулалттай материал		
Хангамжийн материал		
Бичиг хэргийн материал		
Аж ахуйн материал		
Бусад хангамжийн материал		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
Биет хөрөнгө		
Авто-тээврийн хэрэгсэл		
Хуримтлагдсан элэгдэл		
Машин тоног төхөөрөмж		
Хуримтлагдсан элэгдэл		
Тавилга, эд хогшил		
Хуримтлагдсан элэгдэл		
Бусад үндсэн хөрөнгө		
Хуримтлагдсан элэгдэл		
Биет бус хөрөнгө		
Програм хангамж		
Хуримтлагдсан элэгдэл		
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		
Засгийн газрын хувь оролцоо		
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
Өмч: - төрийн		
Хуримтлагдсан үр дүн		
Өмнөх үеийн үр дүн		
Тайлант үеийн үр дүн		
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		




4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
Нийтлэг татварын бус орлого		
Төсөвт байгууллагын өөрийн орлого		
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төвлөрсөн төсвөөс		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
Нэмэлт санхүүжилтийн орлого		
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
УРСГАЛ ЗАРДАЛ		
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
Үндсэн цалин		
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
Тэтгэврийн даатгал		
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
Байрны түрээс		
Хангамж, бараа материалын зардал		
Бичиг хэрэг		
Тээвэр, шатахуун		
Шуудан, холбоо, интернетийн төлбөр		
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
Эд хогшил, урсгал засварын зардал		
Урсгал засвар		
Томилолт, зочны зардал		
Дотоод албан томилолт		
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
Бараа үйлчилгээний бусад зардал		
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
Бусад урсгал шилжүүлэг		
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Тайлант үеийн үр дүн				
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн				
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
Нийтлэг татварын бус орлого		
Төсөв байгууллагын өөрийн орлого		
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төвлөрсөн төсвөөс		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
Нэмэлт санхүүжилтийн орлого		
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		
УРСГАЛ ЗАРДАЛ		
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
Тээвэр, шатахуун		
Бараа үйлчилгээний бусад зардал		
Бараа үйлчилгээний бусад зардал		
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
Бусад урсгал шилжүүлэг		
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
Дотоод эх үүсвэрээр		
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.5 АУДИТ ХИЙГДСЭН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
Нийтлэг татварын бус орлого		
Төсөв байгууллагын өөрийн орлого		
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төвлөрсөн төсвөөс		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
Нэмэлт санхүүжилтийн орлого		
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		
УРСГАЛ ЗАРДАЛ		
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
Тээвэр, шатахуун		
Бараа үйлчилгээний бусад зардал		
Бараа үйлчилгээний бусад зардал		
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
Бусад урсгал шилжүүлэг		
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
Дотоод эх үүсвэрээр		
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

